



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2013 оны 01 сарын 25 өдөр

Дугаар 1/62

Улаанбаатар хот

Нийслэлийн Байгаль орчин, ногоон  
хөгжлийн газрын дүрэм бүтэц, орон  
тоо шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Засгийн газрын 2012 оны 190 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Байгаль орчин, ногоон хөгжлийн газрын дүрмийг нэгдүгээр, бүтэц, орон тоог хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Нийслэлийн Засаг даргын өмнө дүрмээр хүлээсэн үүргээ бүрэн хэрэгжүүлэн, батлагдсан орон тооны хязгаарт багтаан ажилтан, албан хаагчдыг томилох, цалин нэмэгдлийг зохих журмын дагуу тогтоох, хөдөлмөрийн дотоод журам, үйл ажиллагааны стратеги, хэтийн чиглэлийг дүрэмд нийцүүлэн шинэчлэн баталж мөрдөн ажиллахыг нийслэлийн Байгаль орчин, ногоон хөгжлийн газар /Г.Болормаа/-т даалгасугай.

3. Энэ захирамж гарсантай холбогдуулан Нийслэлийн Засаг даргын 2009 оны 147, 2012 оны 07 дугаар захирамжийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА  
БӨГӨӨД УЛААНБААТАР  
ХОТЫН ЗАХИРАГЧ



Э.БАТ-ҮҮЛ

D:\2012 захирамж\Дүрэм.docx

111020000347

Нийслэлийн Засаг даргын 2013 оны  
01 дугаар сарын 05-ны өдрийн  
8/87 дугаар захирамжийн нэгдүгээр  
хавсралт



## НИЙСЛЭЛИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НОГООН ХӨГЖЛИЙН ГАЗРЫН ДҮРЭМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Байгаль орчин, ногоон хөгжлийн газар нь /цаашид "газар" гэх/ байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг зохистой ашиглуулах, нөхөн сэргээх, судалгаа шинжилгээ явуулах, хотын гудамж талбай дахь нийтийн эзэмшлийн ногоон байгууламжийг төлөвлөх, нэмэгдүүлэх, ногоон бүс дэх зуслангийн үйл ажиллагааг удирдан зохицуулах зэрэг экологийн тэнцлийг хангах талаар явуулж байгаа төрийн бодлого, шийдвэрийг нийслэлийн нутаг дэвсгэрт хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий байгууллага мөн.

1.2. Газар нь үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндсэн хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, Улсын Их Хурал, Засгийн газрын тогтоол шийдвэр, Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Засгийн газрын холбогдох агентлаг, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын захирамж, шийдвэр болон энэхүү дүрмийг удирдлага болгоно.

1.3. Газрын дарга нь Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн өмнө ажлаа хариуцаж, тайлагнана.

1.4. Газар нь тогтоосон журмын дагуу хийгдсэн тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэх ба Төрийн сан банкинд харилцах данстай байна.

1.5. Газар нь төсвийн Ерөнхийлөн захирагчтай байгуулсан Үр дүнгийн гэрээг хэрэгжүүлэхийн зэрэгцээ байгууллагын стратеги төлөвлөгөөний дагуу өөрийн үйл ажиллагаанаас бий болсон хөрөнгийг байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад зарцуулж болно.

### Хоёр. Удирдлага, зохион байгуулалт

2.1. Нийслэлийн Засаг дарга нь Газрын бүтэц, орон тооны хязгаарыг тогтоож, газрын даргыг томилж, чөлөөлнө.

2.2. Газрын дарга нь Нийслэлийн Засаг даргатай зөвшилцсөний үндсэн дээр Газрын орлогч дарга бөгөөд Зуслангийн товчооны даргыг томилж, чөлөөлнө.

2.3. Газрын даргыг түр эзгүйд түүний зөвшөөрлөөр албан тушаалын эрх үүргийг нь газрын орлогч дарга хэрэгжүүлнэ.

2.4. Газар нь Захиргаа удирдлагын хэлтэс, Ой, ногоон байгууламжийн хэлтэс, Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн хэлтэс, Зуслангийн товчооноос бүрдэнэ.

2.5. Газрын дотоод нэгжийн үйл ажиллагааны чиг үүрэг, ажилтан, албан хаагчдын ажлын байрны тодорхойлолтыг Газрын дарга батална.

2.6. Газрын дарга нь эрх хэмжээнийхээ асуудлаар тушаал гаргана. Батлагдсан орон тооны хязгаарт багтаан нэгжийн дарга, ажилтан, албан хаагчдыг томилж, чөлөөлнө.

2.7. Газар байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, зүй зохистой ашиглуулах, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх асуудлаар мэргэжлийн бусад байгууллагатай хууль, эрх зүйн хүрээнд хамтран ажиллана.

2.8. Газар нь чиг үүргээ хэрэгжүүлэхтэй холбогдсон асуудлаар Газрын даргад зөвлөх үүрэг бүхий орон тооны бус зөвлөлийг байгуулан ажиллуулж болно. Зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг Газрын дарга батална.

2.9. Газрын төсвийн харилцах дансны нэгдүгээр гарын үсгийг газрын дарга, хоёрдугаар гарын үсгийг газрын нягтлан бодогч нар тус тус зурна.

2.10. Газар нь санхүүжилт, төсвийн гүйцэтгэлийн зарлагын мэдээг сар бүр гаргаж, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын холбогдох хэлтэст хүргүүлнэ.

2.11. Холбогдох хууль тогтоомж, байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын дагуу ажиллагсдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх, мэдлэг ур чадварыг дээшлүүлэх, мэргэшүүлэх талаар шат дараалсан арга хэмжээ авч ажиллана.

2.12. Хуульд эрх олгогдсоны дагуу газрын даргын захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэрийг зохих журмын дагуу Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль эрх зүйн хэлтсээр хянуулж, Хууль зүйн яаманд хүргүүлнэ.

2.13. Газрын ажилтан, албан хаагчдын ёс зүйн хэм хэмжээ, сахилга дэг журмыг сахиулж, тэдгээрийн ажлын цаг ашиглалт, өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтанд хяналт тавьж ажиллана.

Гурав. Үйл ажиллагааны үндсэн чиглэл, эрх үүрэг

3.1. Үйл ажиллагааны үндсэн чиглэл

3.1.1. Нийслэлийн нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг зохистой ашиглуулах, нөхөн сэргээх, судалгаа шинжилгээ явуулах бодлого боловсруулж хэрэгжүүлэх;

3.1.2. Байгаль орчны тухай мэдээлэл, мэргэжлийн болон арга зүйн удирдлагаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг хангах, байгалийн нөөцийн хамтын менежментийн үзэл баримтлалын хүрээнд ногоон хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх;

3.1.3. Нийслэлийн нутаг дэвсгэрийн тодорхой хэсгийг орон нутгийн хамгаалалтад авах ажлыг зохион байгуулах;

3.1.4. Улаанбаатар хотын ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, цэцэрлэгт хүрээлэнг шинээр бий болгох ажлыг төлөвлөх, хэрэгжүүлэх;

3.1.5. Нийслэлийн зуслан бүхий амуудад оршин суугч иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцлийг бүрдүүлэх, ногоон суурьшлын бүс болгон хөгжүүлэх зорилтыг холбогдох байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх.

### 3.2. Газрын хүлээх үүрэг

3.2.1. Газар нь Монгол Улсын Их хурал болон Засгийн газрын тогтоол, шийдвэр, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, тухайн жилийн эдийн засаг, нийгмийн зорилтыг хэрэгжүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлж, хэрэгжилтийн явц, үр дүнг хугацаанд нь тайлагнах;

3.2.2. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх даалгавар, захиалгат ажлын биелэлтийг хангуулж, гүйцэтгэлийг тогтоосон журмын дагуу тухай бүр холбогдох байгууллагад танилцуулах;

3.2.3. Нийслэлийн нутаг дэвсгэрийн байгалийн баялаг /түгээмэл тархацтай ашигт малтмал, ан амьтан, ургамал, хөрс, ой, ус гэх мэт/ болон орчныг бохирдуулах эх үүсвэрийн тооллого бүртгэл судалгаа гаргаж, мэдээллийн сан бүрдүүлэх;

3.2.4. Нийслэлийн ногоон бүсийн байгалийн нөөц баялаг ашигласны төлбөр, хураамж, үнэлгээг мөрдүүлэх, хэрэгжилтийг хангаж ажиллах;

3.2.5. Шинээр байгуулах болон одоо ажиллаж буй үйлдвэр, үйлчилгээний барилга байгууламж, тэдгээрийг шинэчлэх, өргөтгөх болон байгалийн баялгийн нөөц баялаг ашиглах төсөл, арга хэмжээг байгаль орчны нөлөөллийн үнэлгээнд хамруулах;

3.2.6. Нийслэлийн нутаг дэвсгэрт иргэдийн сайн дурын нөхөрлөлд түшиглэсэн байгалийн нөөцийн хамтын менежментийн үзэл баримтлалын хүрээнд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, дэмжин ажиллах;

3.2.7. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын дунд байгаль орчныг хамгаалах хууль тогтоомжийг сурталчлах, мөрдүүлэх, иргэдэд экологийн боловсрол олгох ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулах, ой, ус, хөрс, ургамал, ан амьтан зэрэг байгалийн баялгийг хамгаалах, нөхөн сэргээх, зохистой ашиглахад зориулсан хялбарчилсан гарын авлага, зөвлөмж боловсруулах, олон нийтэд танилцуулах;

3.2.8. Байгаль орчныг хамгаалах ажилд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын санал хүсэлт, мэдээллийг хүлээн авч тэдний оролцоог өргөжүүлэх;

3.2.9. Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх арга хэмжээг нийслэлийн нутаг дэвсгэрт зохион байгуулж, хэрэгжүүлэх;

3.2.10. Тусгай хамгаалалттай газар нутгийн талаарх төрийн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, байгалийн нөөц газар, дурсгалт газрын хамгаалалтыг эрхлэх;

3.2.11. Нийслэлийн ногоон байгууламжийг нэмэгдүүлэх мэргэжлийн үйл ажиллагаатай холбоотой дүрэм, журам, Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий болон хэсэгчилсэн төлөвлөгөөнд тусгагдсан ногоон байгууламжийг нэмэгдүүлэх талаар төсөл хөтөлбөр боловсруулж, шийдвэрлүүлэх;

3.2.12. Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх үйл ажиллагаанд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын оролцоог нэмэгдүүлж, мэргэжил арга зүйн зөвлөгөөгөөр ханган ажиллах;

3.2.13. Зуслангийн хөрс, ус, орчны бохирдлыг бууруулах, нөхөн сэргээх, тохижуулах ажилд зуслангийн зөвлөл, иргэн, аж ахуйн нэгж, байгууллага болон холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах;

3.2.14. Зуслангийн газрыг эзэмшүүлэх, баталгаажуулах, өмчлөхөд байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомжийн дагуу санал, байгаль орчны дүгнэлт гаргах.

### 3.3. Газрын эрх

3.3.1. Нийслэлийн ногоон бүсэд үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын байгаль орчныг хамгаалах хууль тогтоомж зөрчсөн үйлдэлд зохих журмын дагуу арга хэмжээ авах;

3.3.2. Экологид ээлтэй үйлдвэрлэл, технологи, үйл ажиллагааг дэмжих, сөрөг нөлөө үзүүлж буй аж ахуйн нэгж, байгууллагын судалгааг гаргаж, зохих арга хэмжээг авах;

3.3.3. Байгаль орчин, экологийн төлөв байдлыг үнэлэх, хамгаалах асуудлаар шаардагдах мэдээ баримт, судалгааг холбогдох этгээдээс гаргуулж авах;

3.3.4. Төрийн холбогдох дээд шатны байгууллага болон нийслэл, дүүргийн нутгийн захиргааны байгууллагаас гаргасан тогтоол, тушаал, захирамж, журам, заавар, аргачлал, техник технологийн шийдэл нь байгаль орчныг хамгаалах хууль тогтоомжид нийцэхгүй, байгальд сөрөг нөлөө үзүүлэхээр бол бүхэлд нь буюу холбогдох хэсэг, заалтыг хүчингүй болгох, өөрчлөх саналаа тухайн этгээдэд болон эрх бүхий дээд шатны байгууллагад тавьж шийдвэрлүүлэх;

3.3.5. Байгаль орчин-экологийн сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр холбогдох байгууллагуудтай хамтарсан үзлэг шалгалт явуулж дүгнэлт гаргах, илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээг шуурхай зохион байгуулах;

3.3.6. Нийслэл хотын нутаг дэвсгэр, байгалийн нөөц баялгийг зохистой ашиглах, хамгаалах, экологийн тэнцлийг хадгалах бодлогыг хэрэгжүүлэх талаархи санал дүгнэлтээ Нийслэлийн Засаг дарга, Байгаль орчин, ногоон хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тавьж шийдвэрлүүлэх;

3.3.7. Ногоон байгууламжийн үйл ажиллагаанд нийтээр дагаж мөрдөх дүрэм журам, шаардлагыг зөрчсөн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын буруутай үйл ажиллагааг зогсоох, арга хэмжээ авах;

3.3.8. Байгаль хамгаалагчдыг бие хамгаалах техник хэрэгсэл, унаагаар хангах асуудлыг Нийслэлийн Засаг даргад тавьж шийдвэрлүүлэх;

3.3.9. Нийслэлийн Засаг даргаас шилжүүлсэн болон хууль тогтоомжоор олгогдсон бусад эрхийг хэрэгжүүлэх;

3.3.10. Нийслэлийн ногоон бүсэд үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын байгаль хамгаалах төлөвлөгөөг гаргуулан, хэрэгжилтийг хангуулан ажиллах.

#### Дөрөв. Хүлээлгэх хариуцлага

4.1. Газрын дарга, орлогч дарга, ажилтан, албан хаагчид бүтээгдэхүүн нийлүүлэх үр дүнгийн гэрээ болон энэхүү дүрмээр хүлээсэн үүргээ хангалтгүй биелүүлсэн тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээнэ.

#### Тав. Бусад зүйл

5.1. Энэхүү дүрэмд Нийслэлийн Засаг даргын захирамжаар нэмэлт, өөрчлөлт оруулах бөгөөд тэдгээр нь дүрмийн салшгүй хэсэг болно.

5.2. Дүрэмд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг тухай бүр зохих байгууллагад мэдэгдэж бүртгүүлнэ.

Нийслэлийн Засаг даргын 2013 оны  
01 дүгээр сарын 25-ны өдрийн  
0/62 дугаар захирамжийн хоёрдугаар  
хавсралт



БАЙГАЛЬ ОРЧИН, НОГООН ХӨГЖЛИЙН ГАЗРЫН  
БҮТЭЦ, ОРОН ТООНЫ ХЯЗГААР

Байгууллагын нэр	Хэлтэс, зуслангийн товчооны нэр	Орон тооны хязгаар
Байгаль орчин, ногоон хөгжлийн газар	Захиргаа удирдлагын хэлтэс	72 хүртэл
	Хүрээлэн буй орчин байгалийн нөөцийн хэлтэс	Үүнээс Дарга, орлогч дарга бөгөөд зуслангийн товчооны дарга, / гэрээт ажилтан 2/
	Ой, ногоон байгууламжийн хэлтэс	
	Зуслангийн товчоо	